

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД

МАЗУЭ-ҮҮДИЙН ХОЛБООНЫ
ДАРГА

МАЗХ-НЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б. ЦЭРЭНПҮРЭВ

Т. БЯМБАА

АВТО ЗАМЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ 2018-2020 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР

2018 оны 06 сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот


НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 2-р бүлэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь хэсэг, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван тал 2017-2018 оны улсын хэлэлцээрийг тус тус үндэслэн төрийн захиргааны байгууллагыг төлөөлөн Зам, тээврийн хөгжлийн яам, ажил олгогчийг төлөөлөн Монголын авто замчдын холбоо, ажиллагсдыг төлөөлөн Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээрийг байгуулав.

Хэлэлцээрийн зорилго нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр авто замын салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлуудыг дэс дараатай шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж тогтвортой байдлыг хангахад оршино.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн авто замын салбарын өмчийн хэлбэр харгалзахгүй бүх аж ахуйн нэгж, байгууллагууд нь ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд хамтын гэрээ байгуулан ажил олгогчийн оршиж байгаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлэн мөрдөж ажиллана.
- 1.2 Хэлэлцээрийн биелэлт, явц, үр дүнд хэлэлцээр байгуулагч талууд хяналт тавина.
- 1.3 Авто замын салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд хамтын гэрээний биелэлтийг энэхүү хэлэлцээрийн хавсралтад заасан маягтын дагуу гаргаж оны эцэст Зам тээврийн хөгжлийн яам, Монголын авто замчдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбоо, Монголын авто замчдын холбоонд хүргүүлнэ.
- 1.4 Авто замын салбарын аж ахуйн нэгжүүдийн орлого, ашгийг нэмэгдүүлэхэд Зам тээврийн хөгжлийн яам, Монголын авто замчдын холбоо, Монголын авто замчдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбоо хуулийн хүрээнд бодлого, үйл ажиллагаагаар дэмжинэ.



1036

Улсын Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар талууд бүх түвшинд хамтран ажиллана.

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР

- 2.1 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа авто замын салбарын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд хөдөлмөр эрхлүүлэхээр гадаадаас авах ажиллах хүчний эзлэх хувийг тухайн аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 20 хувиас хэтрүүлэхгүй байна.
- 2.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын компани зээл, тусламжийн хөрөнгө оруулалт болон Концессын гэрээгээр авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэх тохиолдолд 50-иас доошгүй хувьд нь үндэсний ажиллах хүчнийг ажиллуулах заалтыг гэрээ хэлэлцээрт тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.3 Авто замын салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийг хангах, нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэхдээ тухайн байгууллагын ажиллагсдын болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангана.
- 2.4 Ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад хүргэх орон тоо бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх тохиолдолд аж ахуйн нэгж байгууллага, /ажил олгогч/ нь Монголын авто замчдын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбоонд 45 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашгийг хангах, нийгмийн хамгааллыг хангах талаар гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албанд мэдэгдэнэ.
- 2.5 Авто замын салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтнуудтай хамтын гэрээ, хэлэлцээрт заасан нийгмийн баталгаа, хөдөлмөрлөх нөхцөлийг хангах асуудлыг тусган хөдөлмөрийн гэрээг байгуулж бичгээр 2 хувь үйлдэн тус тус хадгална.
- 2.6 Авто замын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах, хувьчлах тохиолдолд өндөр насны тэтгэвэрт гарсан, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас группт орсон ажилтны харьяалал, нийгмийн хамгааллын асуудлыг хувьчилж авсан болон үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулах байгууллагад хариуцуулна.
- 2.7 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон тахир дутуугийн групп тогтоолгосон ажилтан, мөн өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг тэдний мэргэжил ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор эрүүл мэндэд нь харшлахгүй ажлын байраар хангахад ажил олгогчийн зүгээс анхаарна.
- 2.8 Авто замын салбарын хэмжээнд “Бүтээмжийн хөдөлгөөн” өрнүүлэн талуудын оролцоотой бүтээмжийн зөвлөл байгуулж, чиглүүлэгч нарыг бэлтгэх сургалтыг хамтран зохион байгуулна.
- 2.9 Авто замын салбарт ажиллагсдын ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжид талууд хамтран судалгаа хийж “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллана.
- 2.10 Авто замын салбарт ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.
- 2.11 Авто замын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудад чиглэсэн бодлого явуулж жендерийн тэгш оролцоог хангана.

*2.1 дүгээр заалтын
хэсэг*

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын тус хамтын
хөдөлмөрийн бүтээгч


шилдвэр арьсан тохиолдолд тухайн байгууллагын ажилтнуудын ажлын байрны баталгаа, нийгмийн хамгааллын асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай Зам, тээврийн хөгжлийн яам болон Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо хэлэлцээр хийж, тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэнэ.

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР

- 3.1 Авто замын салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хамтын гэрээгээр харилцан тохиролцох ба мэргэжилтэй ажилтны цалингийн доод хэмжээг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан тарифыг мөрдөнө.
- 3.2 Авто замын засвар арчлалтын компаниудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 400.000 /дөрвөн зуун мянган төгрөг/ -өөс багагүй байна.
- 3.3 Зам тээврийн сайдын 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 186 тоот тушаалаар батлагдсан "Зам, замын байгууламжийн барилга засварын ажлын төсөв бодох заавар ЗЗБНБД 81-013-2016 норм дүрэм"-д заасан тарифыг мөрдөж ажиллана.
- 3.4 Хөдөлмөрийн хэвийн бус /хүнд, хортой/ нөхцөлд ажиллаж байгаа ажиллагсдын цалинг тооцохдоо цагийн тарифт цалингийн жишиг хэмжээг 10,8 хувиар өсгөж тооцно.
- 3.5 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-д орсон ажил мэргэжлийн дагуу тодорхойлно.
- 3.6 Авто замын салбарын аж ахуйн нэгж байгууллагууд нь үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хэрэглээний үнэ, тарифын өсөлт зэргийг харгалзан үндсэн цалин ба нэмэгдлийг аль болох нэмэгдүүлэх чиглэлийг баримтална.
- 3.7 Авто замын салбарын мэргэжил эзэмшсэн хүнийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр дагалдангаар ажиллуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр цалинжуулна.
- 3.8 Авто замын салбарт ажиллаж байгаа зөвлөх инженерт үндсэн цалингийн 15 хувиар, мэргэшсэн болон тэргүүлэх инженерт 10 хувийн нэмэгдэл цалин тус тус олгоно.
- 3.9 Авто замын салбарын ажил мэргэжлийн аварга болсон ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр нэг удаа шагнана.

ДӨРӨВ. АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖИЛ БОЛОВСРОЛЫН ТАЛААР

- 4.1 Авто замын салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн захиргаа нь ажилтнуудаа Зам тээвэр хөгжлийн яам, Монголын авто замчдын холбоо, Монголын авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалт, семинар, бусад үйл ажиллагаанд оролцож байх нөхцөлийг хангана.
- 4.2 Ажил олгогч нь ажилтны мэргэжил, чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж байна.
- 4.3 Инженер техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжил олгох, сургалтыг талууд хамтран зохион байгуулж, сертификат олгож байна.
- 4.4 Авто замын салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, ажлын туршлага, мэдээлэл солилцох арга хэмжээг талууд хамтран зохион байгуулна.
- 4.5 Авто замын салбарын хэмжээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, ажилтнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 3 хүртэлх сарын хугацаатай зохион байгуулагдаж байгаа сургалтад хамрагдсан ажилтанд тарифт цалинг олгож байна.




- дүрсэлж, дурдгалтай талууд хэргийнхэнд талуулан, сурталчлах, андрэн тэмдэглэх арга хэмжээг талууд хамтран зохион байгуулна.
- 4.7 Өөрийн санаачилга, хөрөнгөөр тодорхой мэргэжлээр ажилтныг сургаж мэргэжил олгох, ажлын байр шинээр бий болгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зэрэг чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулсан ажил олгогчдыг шалгаруулан урамшуулж үйл ажиллагааг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг талууд хамтран зохион байгуулна.
- 4.8 Авто замын салбарын мэргэжлийн боловсролын зөвлөлийг талуудын оролцоог ханган хамтран байгуулж ажиллуулна.

ТАВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР

- 5.1 Авто замын салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон түүнтэй холбогдсон хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөрийг талууд хамтран боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.2 Авто замын салбарт ажиллагсдыг төрийн одон медаль, шагналд тодорхойлох, Авто замчдын өдөр, салбарын ой, авто замчдын шинэ жилийн баярыг тэмдэглэх зэрэг арга хэмжээг талууд хамтран зохион байгуулж, шагнаж урамшуулна.
- 5.3 Авто замын салбарт ажиллагсдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын байдалд судалгаа хийж, нөхцөл боломжийг сайжруулах ажлыг хамтран зохион байгуулна.
- 5.4 Байгууллагын болон авто замын салбарын нэрийн өмнөөс улс, хотын чанартай урлаг, спортын тэмцээн, уралдаанд оролцон амжилт гаргасан ажилтныг шагнаж урамшуулна.
- 5.5 Авто замын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын дунд спортын наадам, уралдаан тэмцээнийг жил бүр, урлагийн наадмыг 2 жил тутам хамтран зохион байгуулна.
- 5.6 Авто замын салбарын хэмжээнд нормчлогдоогүй ажлуудын үйлдвэрийн болон төсвийн норм, нормативыг судалж шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтооно.
- 5.7 Төрийн өмчит компанид ажилладаг ажилтны нэг хүүхдийн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэхийг холбогдох байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх талаар хамтран ажиллана.

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

- 6.1 “Зам, тээврийн ажилчдын ажил, амралтын тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 152 дугаар конвенцод нэгдэх асуудлыг талууд хамтран судална.
- 6.2 Авто замын салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамтын ажиллагааны хороог байгуулан ажиллуулж үйлдвэрлэлийн явцад гарсан аваар осол гэмтлийг судлан бүртгэх, ослыг тэглэх арга хэмжээ авна.
- 6.3 Үйлдвэрлэлийн осол гаргаагүй аж ахуйн нэгж байгууллага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан ажилтныг урамшуулах журмыг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.
- 6.4 Жил бүрийн 4 дүгээр сарын 28–нд “Үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдсэн, ажилчдыг хүндэтгэх дэлхийн өдөр”-ийг авто замын салбарын хэмжээнд ослоор амь эрстсэн, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас осолд орсон, групп тогтоолгосон хүмүүст хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулна.
- 6.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг аж ахуйн нэгж байгууллага, ажиллагсдад сурталчлах, “Авто замын салбарын хөдөлмөрийн аюулгүй




- 6.6 Аж ахуйн нэгж, байгууллагуудад ажлын байрны эрүүл ахуйн орчныг бүрдүүлэх болон ХДХВ/ДОХ-оос сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.

ДОЛОО. ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД

- 7.1 Авто замын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах, зарцуулалт, гүйцэтгэлийн талаарх хэлэлцүүлэгт ажил олгогч болон ажилтны хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллагын оролцоог хангаж, зөвлөлдөнө.
- 7.2 Авто замын салбарын төрийн захиргааны байгууллага нь гүйцэтгэгч талтай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний санхүүжилтийг хугацаандаа олгоогүй тохиолдолд гүйцэтгэгчид төлөх торгуулийн хувь хэмжээг гэрээний тусгай нөхцөл болгон тодорхой тусгаж, баталгаажуулна.
- 7.3 Авто замын салбарын ажиллагсдын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал болон хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд талууд хамтарсан үзлэг шалгалт хийнэ.
- 7.4 Авто замын тухай хууль болон бусад холбогдох хуулийн төслийг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулахад авто замын салбарын ажил олгогч болон ажилтныг төлөөлөгч байгууллагын саналыг тусгаж хамтран ажиллана.
- 7.5 Авто замын салбарын ажил мэргэжлийн нэгдсэн жагсаалт гаргахад талууд хамтран ажиллана.
- 7.6 Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах хороог талууд хамтран байгуулж ажиллуулна.
- 7.7 Авто замын салбарын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчин, цалин хөлсний байдалд хамтарсан судалгаа хийнэ.
- 7.8 Хамтын гэрээний биелэлтийг талууд жил бүр гарган холбогдох байгууллагуудад мэдээлнэ.

НАЙМ. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ МӨРДӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

- 8.1 Энэхүү хэлэлцээр нь талуудын гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс хойш хоёр жилийн хугацаанд хүчинтэй. Хэлэлцээрт талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 8.2 Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.
- 8.3 Уг хэлэлцээрийн биелэлтийг талууд жил бүр гаргаж, хамтран дүгнэж талуудын төлөөлөгчдийн хамтарсан хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээг тухай бүр авч байна.
- 8.4 Хамтын хэлэлцээрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг талууд хамтран боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.
- 8.5 Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, өмчлөлийн харьяалалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын хэлэлцээрээр тохирсон асуудлыг цуцлах үндэслэл болохгүй.
- 8.6 Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд төлөөлөгчдийн хуралдааныг аль нэг тал нь 7 хоногийн дотор хуралдуулах санал оруулан хуралдуулна.
- 8.7 Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдсэн маргааныг Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



ЗАМ ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН АВТО
ЗАМЧДЫН ҮЭ-ҮҮДИЙН
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН АЖИЛ
ОЛГОГЧ ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБООГ
ТӨЛӨӨЛЖ:

Авто замын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Э. Энхбат

Авто замын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын ЗАЗХ-ийн дарга

Х. Оргил-эрдэнэ

Нийслэлийн авто замын
хөгжлийн газрын дарга

Ж. Тогтохбаяр

"Зам тээврийн хөгжлийн төв"
ААТТӨҮГ-ын захирал

Р. Буд

Бодлого төлөвлөлтийн
газрын ахлах мэргэжилтэн

М. Угтахбаяр

Бодлого төлөвлөлтийн
газрын Хөрөнгө оруулалт,
үйлдвэрлэлийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Г. Алтангэрэл

Авто замын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын мэргэжилтэн

С. Баярчимэг
Төрийн захиргааны
удирдлагын газрын Хуулийн
хэлтсийн мэргэжилтэн

Д. Оюунсүрэн

МАЗҮЭ-үүдийн холбооны
тэргүүдэгч

Р. Равжаа

МАЗҮЭ-үүдийн холбооны
тэргүүлэгч

Д. Болдбаатар

"Төв АЗЗА" ТӨХК-ийн
ҮЭХорооны дарга

Ш. Оюунтунгалаг

"Ялгуусан" ХХК-ийн
ҮЭХорооны дарга

Г. Нэргүй

"Налайх АЗЗА" ТӨХК-ийн
ҮЭХорооны тэргүүлэгч

О. Чинболд

"Гангүүр" ХХК-ийн
ҮЭХорооны дарга

Г. Ганбат

"Баткубик" ХХК-ийн ҮЭ-ний
хорооны дарга

Г. Цанлиг

МАЗҮЭ-үүдийн холбооны
зөвлөх

Ж. Шуумаржав

МАЗХ-ны гүйцэтгэх
захирал

А. Уранчимэг

МАЗХ-ны удирдах
зөвлөлийн гишүүн,
"Хязгааргүй хөдөлгөөн"
ХХК-ийн зөвлөх

Б. Энхтөр

МАЗХ-ны удирдах
зөвлөлийн гишүүн,
"Заабар" ХХК-ийн захирал

О. Батбаяр

МАЗХ-ны удирдах
зөвлөлийн гишүүн, "Лабо"
ХХК-ийн захирал

Ч. Лхагважав

"Гангүүр" ХХК-ийн ерөнхий
инженер

Н. Лхагвадорж

"Насны зам" ХХК-ийн
гүйцэтгэх захирал

Ч. Болормаа

"Монголын хурдын зам"
ХХК-ийн гүйцэтгэх захирал

О. Оюунтунгалаг

"Арж капитал" ХХК-ийн
эдийн засагч

И. Уянга

